




# Хүний эрхийн хамгаалагчийн тунхаглал

Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах, хангах хувь хүн, бүлэг хүмүүс, нийгмийн байгууллагын эрх үүргийн тухай тунхаглал



Тунхаглалыг баталсан өдөр

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейн зөвшилцлөөр баталсан



хүний эрхийн хамгаалагч гэж хэн бэ?



Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эмэгтэйчүүд, уугуул иргэдийн эрх эсхүл гей, лесбиян, трансжендэр, интерсекс хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалахын төлөө ажилладаг жирийн эрэгтэй, эмэгтэй хэн ч байж болно. Энэхүү үйлдлийг тэд ганцаар эсхүл аль нэг байгууллагад нэгдэн хийдэг байж болно.

Та хүний эрхийн хамгаалагчийг хэрхэн дэмжиж болох вэ?



- Хүний эрхийн хамгаалагчийн тухай тунхаглалын мэдээллийг түгээх
- Хүний эрхийн хамгаалагчийн ажлыг хүлээн зөвшөөрөхөд хувь нэмэр оруулах
- Хүний эрхийн хамгаалагчид тусалдаг, тэднийг хамгаалдаг байгууллагыг дэмжих
- Эрсдэлд байгаа хүний эрхийн хамгаалагчийн төлөө ажиллах
- Хүний эрхийн хамгаалагч болох! Учир нь хүн бүр хүний эрхийг хамгаалах, хангах эрх, үүрэгтэй.

Тунхаглалын эрх зүйн байдал нь юу вэ?

Тунхаглал нь хүний эрхийг батлан хамгаалах, хангах үүрэг, хариуцлага хүлээлгэдэг олон улсын хуулиудад үндэслэх ба тэдний үзэл санааг нэгтгэн илэрхийлнэ.

## Хүний эрхийн хамгаалагчдын эдлэх эрх ба хамгаалалтууд

Хүний эрхийг өөрийн улсад болон дэлхий дахинд хөхиулэн дэмжих	Ганцаар болон бусадтай нийлэн хүний эрхийг хамгаалах	Холбоо, төрийн бус байгууллага байгуулах	Тайван уулзалт, цуглаан зохион байгуулах, оролцох	Хүний эрхтэй холбоотой мэдээлэл хайх, олж авах, хадгалах	Хүний эрхийн шинэ санаа, зарчмыг боловсруулах, хэлэлцүүлэх, хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө ажиллах
Албан тушаалтны үйл ажиллагааг шүүмжлэх, сайжруулах санал гаргах, хүний эрхийн хэрэгжилтэнд саад болох аливаа аюул, эрсдэлийн тухай анхааруулах	Хүний эрхтэй холбоотой төр засгийн бодлого, үйл ажиллагааны тухай гомдол гаргах, хянуулах	Хүний эрхийг хамгаалахад мэргэжлийн түвшинд чанартай хуулийн зөвлөгөө, тусламж санал болгох, үзүүлэх	Нийтийн сонсгол, шүүх хурал зэрэгт сууж олон улсын хүний эрхийн үүрэг, үндэсний хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг үнэлэх	Ямар нэг хязгаарлалтгүйгээр төрийн бус болон засгийн газар хоорондын байгууллагуудтай харьцах	Гомдол, хохирлоо барагдуулах, үр шимийг хүртэх
Хүний эрхийн хамгаалагчийн мэргэжил, ажлыг хуулийн дагуу эрхлэх	Хүний эрхийн зөрчлийг эсэргүүцэн тайван үйл ажиллагаа явуулахдаа үндэсний хууль тогтоомжоор хамгаалуулах	Хүний эрхийг хамгаалах зорилгоор хөрөнгө, нөөц дайчлах, цуглуулах, зарцуулах			

## төрийн үүрэг

Хүний бүх эрхийг хамгаалах, хангах, хэрэгжүүлэх	Харьяат хүн бүр хүний бүх эрх, эрх чөлөөг эдлэх явдлыг баталгаажуулах	Хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг баталгаатай хангах хуулийн, захиргааны болон бусад шаардлагатай арга хэмжээ авах	Хүний эрхийн зөрчлөөс болж хохирсон хүмүүст хохирлыг бодитойгоор барагдуулах	Илэрсэн хүний эрхийн зөрчилд шуурхай, хараат бус мөрдөн шалгах үйл ажиллагаа хийх	Хүний эрхийн ажлаас нь шалтгаалан учирсан хүчирхийлэл, сүрдүүлэг, хонзон, алагчлал, дарамтлал эсхүл өөр дүр мэдэн үйлдэх ажиллагаанаас хүн бүрийг хамгаалах бүхий л шаардлагатай арга хэмжээг авах, хамгаалалтыг баталгаажуулах
			Иргэний, улс төрийн болон эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах	Үндэсний, бие даасан хүний эрхийн байгууллагыг үүсгэн байгуулах, хөгжүүлэн бэхжүүлэх явдлыг дэмжих, баталгаажуулах	Бүх түвшиний албан боловсрол болон мэргэжлийн сургалтанд хүний эрхийн хийчээлийг нэвтрүүлэхийг хөхиулэн дэмжих, хувь нэмэр оруулах

## Хүн бүрийн хүлээх хариуцлага

Хүний эрхийг хангах, ардчилал болон түүний институтийг сахин хамгаалах ба бусдын эрхийг зөрчихгүй байх.	Бусдын эрхийг хөндөх ажил хийдэг хүмүүс ялангуяа цагдаа, хуульч, шүүгчид эдгээр эрхийг хамгаалж хариуцлага хүлээдэг байх.	
---	---	--